



БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ИРГЭНИЙ ХЭРГИЙН АНХАН ШАТНЫ ШҮҮХЭД  
НЭХЭМЖЛЭЛ ГАРГАХ НЬ

2024.00.00  
ХОТ

Улаанбаатар

Нэхэмжлэгч: Оршин суугаа газрын хаяг, ургийн овог, эцгийн нэр, өөрийн нэр, регистрийн дугаар, утасны дугаар

Нэхэмжлэлийн шаардлага: **Ажиллаж байсан байдлыг тогтоолгох тухай**

1 Миний бие 1981 оны 12 сарын 25-ны өдрөөс 1993 оны 12 сарын 31-ний өдрийг хүртэл Оёдолын үйлдвэрүүдийн нэгдлийн харъяа Хүүхдийн хувцасны үйлдвэрийн 2 дугаар тасагт оёдолчиноор, 1994 оны 01 сарын 05-ны өдрөөс 1998 оны 12 сарын 25-ны өдрийг хүртэл Тэмүжин менч ББХК-д оёдолчиноор ажиллаж байсан.

2 Одоо өндөр насны тэтгэвэр тогтоолгох гэтэл тухай үед байгууллагаас олгосон хөдөлмөрийн дэвтэрийг үрэгдүүлсэн, 1993 онд ажлаас чөлөөлсөн, 1994 онд Тэмүжин менч ББХК-д оёдолчиноор томилсон тушаал байхгүй шалтгаанаар оёдолчиноор ажилласан 16 жил хасагдах байдалд хүрээд байна.

3 Би холбогдох баримтыг бүрдүүлэн шүүхэд өөрийн ажиллаж байсан байдлыг тогтоолгохоор нэхэмжлэл гаргаж байна.

Миний 1981 оны 12 сарын 25-ны өдрөөс 1993 оны 12 сарын 31-ний өдрийг хүртэл Оёдолын үйлдвэрүүдийн нэгдлийн харъяа Хүүхдийн хувцасны үйлдвэрт оёдолчиноор, 1994 оны 01 сарын 05-ны өдрөөс 1998 оны 12 сарын 25-ны өдрийг хүртэл Тэмүжин менч ББХК-д оёдолчиноор ажилласан 16 жилийн хугацааг тус тус тогтоож өгнө үү.

Нэхэмжлэлд хавсаргасан баримтууд:

1. Нэхэмжлэл 1 хувь
2. Миний иргэний үнэмлэхийн хуулбар, /нотариатаар батлуулна/
3. Миний хөдөлмөрийн дэвтрийн хуулбар, /нотариатаар батлуулна/
4. Баянгол дүүргийн 00-р хороонд оршин суудаг тухай хорооны Засаг даргын тодорхойлолт
5. Үндэсний төв архив, Нийслэлийн архивын тодорхойлолт
6. Гэрч Б.Б, Д.Д нарын иргэний үнэмлэхийн хуулбар, /нотариатаар батлуулна/
7. Гэрч Б.Б, Д.Д нарын хөдөлмөрийн дэвтрийн нотариатчаар гэрчлүүлсэн
8. Гэрч Б.Б, Д.Д нарын тодорхойлолт, нотариатчаар гэрчлүүлсэн
9. Ажиллаж байх үедээ шагнагдаж байсан баярын бичиг, сайшаалын үнэмлэх зэргийг нотлох баримтаар өгч болно
10. Ажиллаж байх үеийн хамт олноор болон ажлын байранд татуулсан фото зураг нотлох баримтаар өгч болно
11. Улсын тэмдэгтийн хураамж 70200 төгрөг тушаасан баримт

Нэхэмжлэл гаргасан:

Нэр ... гарын үсэг ... гарын үсгийн тайлал